



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/991

Чингис хот

Коронавирусын халдвар /КОВИД-19/
цар тахлын болзошгүй эрсдэлийг бууруулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.20. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, аймгийн Онцгой комиссын 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 28 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирусын халдвар /КОВИД-19/ цар тахлын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх аймгийн нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис худалдан авахад зориулж хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах 27065700 /хорин долоон сая жаран таван мянга долоон зуун/ төгрөгийг Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ